



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/109/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayag@audit.gov.mn</p> <p>Аудитор:Ц.Алтантуул Утас: 91195554 Цахим хаяг : tuul9565@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.22 № 302/22

танай _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭХАЙРХАН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ Ц.ДУЛМАА-Д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний Эрдэнэхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

2,580.0 мянган төгрөгийн жолоочийн тооцоог бодоогүй, ажилтны амралтын цалинг олгохдоо 358.5 мянган төгрөгийн НДШ болон ХХОАТ-ы суутгаагүй, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийж гүйцэтгээгүйгээс 13,458.4 мянган төгрөгийн эм боох материалыг нягтлан бодох бүртгэлд буруу дүнгээр тусгасан, 20,388.1 мянган төгрөгийн эмийн худалдан авалтыг хийхдээ анхан шатны баримтыг бүрдүүлээгүй, 11,673.6 мянган төгрөгийн бараа материалын тайланг буруу гаргаж үлдээгдлийг буруу тооцсон, 22,738.1 мянган төгрөгийн и баримтыг бүрдэл дутуу зэрэг зөрчил нь (Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1, 12.2.1, 13.1, 13.6, 13.7, 20.2.6 дахь заалтууд, Төсвийн тухай хуулийн 6.4.1, заалт зэрэгтэй нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй) байна.

013022023

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34.00	93.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	0.00
3121	Төгрөг	-	0.00
31211	Төрийн сангийн харилцах	-	0.0001
33	АВЛАГА	0.01	32.38
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.01	0.04
335	Бусад авлага	-	32.34
3351	Байгууллагаас авах авлага	-	32.34
35	БАРАА МАТЕРИАЛ	33.98	60.81
351	Түүхий эд материал	7.16	18.09
35110	Тусгай зориулалттай материал	5.16	6.42
35130	Эм боох материал	2.00	11.67
354	Хангамжийн материал	26.82	42.72
35410	Бичиг хэргийн материал	2.07	2.56
35420	Аж ахуйн материал	4.37	11.26
35430	Сэлбэг хэрэгсэл	2.71	2.71
35460	Хүнсний материал	1.53	0.94
35470	Бусад хангамжийн материал	16.14	25.26
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	371.39	352.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	371.39	352.83
392	Биет хөрөнгө	360.96	342.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	359.06	359.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	(43.58)	(56.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57.18	57.18
39204	Хуримтлагдсан элэгдэл	(44.58)	(50.26)
39205	Машин тоног төхөөрөмж	66.66	73.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51.48)	(56.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22.71	22.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10.97)	(13.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13.91	14.39
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7.96)	(8.81)
393	Биет бус хөрөнгө	10.43	10.43
39301	Програм хангамж	1.11	1.11
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1.11)	(1.11)
39303	Бусад биет бус хөрөнгө	10.43	10.43
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	405.39	446.03
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	18.93
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	18.93
413	Өглөг	-	18.93
4136	Бусад өглөг	-	18.93
41361	Байгууллагад төлөх өглөг	-	18.93

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	405.39	427.10
51	Засгийн газрын хувь оролцоо	405.39	427.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	179.48	179.48
51101	Өмч: - төрийн	179.48	179.48
512	Хуримтлагдсан үр дүн	(78.96)	(57.24)
51210	Өмнөх үеийн үр дүн	(32.28)	(78.96)
51220	Тайлант үеийн үр дүн	(46.68)	21.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	304.86	304.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	405.39	446.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/сая төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	369.54	462.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4.27	36.89
120	Нийтлэг татварын бус орлого	4.27	36.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4.27	36.89
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4.27	36.89
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	365.28	425.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	325.54	389.46
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	296.23	345.82
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	29.32	43.65
1330	Төсвийн захирагчдаас	-	25.51
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	25.51
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14.14	10.51
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	10.51
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	399.01	440.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	399.01	440.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387.21	414.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222.83	268.93
210101	Үндсэн цалин	222.83	268.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28.85	34.84
210201	Тэтгэврийн даатгал	19.35	25.11
210202	Тэтгэмжийн даатгал	2.37	2.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	1.90	1.97
210204	Ажилгүйдлийн даатгал	0.47	0.49
210205	Эрүүл мэндийн даатгал	4.75	4.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24.62	24.07

Эрдэнэхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	1.67	1.61
210302	Түлш, халаалт	22.96	22.46
2104	Хангамж, бараа материалын зардал	35.58	23.75
210401	Бичиг хэрэг	2.43	1.31
210402	Тээвэр, шатахуун	17.75	18.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1.30	1.14
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5.35	3.25
2105	Нормативт зардал	39.25	16.18
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34.77	8.31
210502	Хоол, хүнс	4.48	7.86
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	0.07
210604	Урсгал засвар	-	0.07
2107	Томилолт, зочны зардал	0.55	1.41
210702	Дотоод албан томилолт	0.55	1.41
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.38	0.31
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.21	0.21
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.04	0.02
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.01	0.01
210807	Газрын төлбөр	0.05	0.05
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	0.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35.15	44.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8.49	18.54
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26.66	25.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11.80	26.60
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	11.80	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	11.80	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	26.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(29.47)	21.72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(46.68)	21.72

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
С01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	179.48	306.39	-29.21	456.66
С03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	179.48	306.39	-29.21	456.66

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	-2.92	-2.92
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-46.68	-46.68
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	179.48	304.86	-77.28	407.06
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	179.48	304.86	-78.96	405.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	179.48	304.86	-78.96	405.39
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	21.72	21.72
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	179.48	304.86	-57.24	427.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/сая төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	365.28	425.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	365.28	425.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	325.54	389.46
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	296.23	345.82
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	29.32	43.65
1330	Төсвийн захирагчдаас	-	25.51
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	25.51
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14.14	10.51
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	10.51
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	355.55	425.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	355.55	425.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	343.75	398.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222.83	268.93
210101	Үндсэн цалин	143.66	152.86
210102	Нэмэгдэл	58.93	93.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3.72	4.45
210104	Урамшуулал	16.53	18.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28.86	34.87
210201	Тэтгэврийн даатгал	19.37	25.14
210202	Тэтгэмжийн даатгал	2.37	2.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	1.90	1.97
210204	Ажилгүйдлийн даатгал	0.47	0.49
210205	Эрүүл мэндийн даатгал	4.75	4.81

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24.62	24.09
210301	Гэрэл, цахилгаан	1.67	1.61
210302	Түлш, халаалт	22.96	22.46
210303	Цэвэр, бохир ус	-	0.02
2104	Хангамж, бараа материалын зардал	24.79	24.07
210401	Бичиг хэрэг	1.81	2.20
210402	Тээвэр, шатахуун	17.00	18.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1.30	1.18
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	0.49
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4.21	2.14
2105	Нормативт зардал	33.51	29.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24.87	20.42
210502	Хоол, хүнс	4.05	7.31
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4.59	1.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1.98	3.61
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.32	1.76
210604	Урсгал засвар	1.39	1.85
2107	Томилолт, зочны зардал	0.55	1.41
210702	Дотоод албан томилолт	0.55	1.41
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.38	0.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.21	0.21
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.04	0.02
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.01	0.01
210807	Газрын төлбөр	0.05	0.05
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	0.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6.23	12.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6.23	11.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	0.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11.80	26.60
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	11.80	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	11.80	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	26.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9.73	0.0001
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	0.0001
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.0001

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	373.34	381.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373.34	381.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	372.77	381.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257.21	268.93
210101	Үндсэн цалин	150.11	152.86
210102	Нэмэгдэл	79.05	93.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4.81	4.45
210104	Урамшуулал	23.24	18.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34.72	34.87
210201	Тэтгэврийн даатгал	24.44	25.14
210202	Тэтгэмжийн даатгал	2.57	2.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	2.06	1.97
210204	Ажилгүйдлийн даатгал	0.51	0.49
210205	Эрүүл мэндийн даатгал	5.14	4.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24.75	24.09
210301	Гэрэл, цахилгаан	2.29	1.61
210302	Түлш, халаалт	22.34	22.46
210303	Цэвэр, бохир ус	0.13	0.02
2104	Хангамж, бараа материалын зардал	23.71	23.03
210401	Бичиг хэрэг	2.18	2.11
210402	Тээвэр, шатахуун	17.91	17.91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1.68	1.18
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.58	0.49
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1.31	1.34
2105	Нормативт зардал	21.57	23.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14.80	16.16
210502	Хоол, хүнс	5.07	5.45
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1.70	1.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1.79	2.41
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.73	0.56
210604	Урсгал засвар	0.75	1.85
2107	Томилолт, зочны зардал	1.33	1.20
210702	Дотоод албан томилолт	1.33	1.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.91	0.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.21	0.21
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.07	0.02
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.01	0.01

210807	Газрын төлбөр	0.05	0.05
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.05	0.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6.77	3.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6.77	3.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	0.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.57	0.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	330.82	345.82
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	330.82	345.82
122005	Орон нутгийн төсвөөс	330.82	345.82

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	43.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	43.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	17.05
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1.03
210401	Бичиг хэрэг	-	0.09
210402	Тээвэр, шатахуун	-	0.14
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	0.80
2105	Нормативт зардал	-	6.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	4.26
210502	Хоол, хүнс	-	1.86
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1.20
2107	Томилолт, зочны зардал	-	0.21
210702	Дотоод албан томилолт	-	0.21
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	26.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	26.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26.60

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер Аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Эрдэнэхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэхайрхан сумын Эрүүл мэндийн төв нь иргэн таны бие сэтгэлийг эмчилж, чанартай амьдралыг бий болгох гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сантмаргац сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын

дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн нийт зардлын 211.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 440.7 сая төгрөгийн 1.5 хувь буюу 6.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг түүний 75 хувь буюу 5.0 сая төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	14.7	32,384.80	32,370.20
Бараа материал	33,981.20	60,811.20	26,830.00
Үндсэн хөрөнгө	371,390.0	352,830.70	18,559.30
Нийт хөрөнгө	405,385.90	446,026.7	40,640.8
Өр төлбөр	0	18,925.50	18,925.50
Засгийн газрын хувь оролцоо	405,385.90	427,101.20	21,715.50
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	405,385.90	446,026.7	40,640.8

Авлага дансны үлдэгдэл 32,370.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд эрүүл мэндийн даатгалын сангаас тооцоо үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын данс 26,830.0 мянган төгрөгөөр өссөн нь цаг үеийн шаардлагаар эм боох материал худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 18,559.3 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагын хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл өссөнтэй холбоотой байна.

Өр төлбөр 18,925.5 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материалын тооцоо үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 21,715.5 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 381,820.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 381,820.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 345,815.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 25,506.4 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 10,506.5 мянган төгрөгийн, нийт 381,827.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 381,824.2 мянган төгрөгийг зарцуулж, 2.7 мянган төгрөгийг төвлөрүүлж 0.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант эрүүл мэндийн яам болон бусад байгууллагаас дээд 43,649.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлсэн.

Нэмэлт орлогоос 26,600.0 мянган төгрөгийг албан хаагчдын тэтгэмжинд 8,489.5 мянган төгрөгийг вакцины урамшуулал 8,560.4 мянган төгрөгийг нэг удаагийн хамгаалах хэрэгсэл болон бусад зүйлд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Анхан шатны баримтыг бүрдүүлэлгүйгээр худалдан авалт хийдэг, шатахууны тооцоог боддоггүй, хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийдэггүй, өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, бараа материалын тайланг хуулийн дагуу бэлтгэн гаргадаггүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 131 мэдээлэл, хугацаа хоцроосон 18 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэхэд шилэн дансанд мэдээлэл байршуулахдаа хугацаа хоцроосон байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэр аудит хийгдсэн бөгөөд зөвлөмж өгөгдөөгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагад ашиглагдаж байгаа хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 516.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс, 478.5 сая төгрөгийн алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 20.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 17.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

- ✓ 413.6 сая төгрөгийн хөрөнгийн тооллого хийгээгүй
- ✓ 32.3 сая төгрөгийн авлагыг тусгаагүй
- ✓ 18.9 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлээгүй
- ✓ 13.5 сая төгрөгийн эм боох материалыг зөрүүтэй дүнгээр бүртгэлд тусгасан зэрэг зөрчлүүдийг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Ажлаас халагдсан ажилтанд 0.3 сая төгрөгийн амралт, цалинг давхардуулан олгосон, тус цалингаас НДШ суутгаагүй олгосон .

4.3 Албан шаардлага

20.4 сая төгрөгийн эм боох материалыг худалдан авахдаа бараа материалын зарлагын баримт, төлбөрийн нэхэмжлэх, и баримтыг бүрдүүлээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийг ноцтой зөрчсөн тул албан шаардлага хүргүүлж байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ 2.6 сая төгрөгийн шатахууны тооцооны хуудсыг эрх бүхий ажилтнууд хянаж баталгаажуулаагүй, шатахууны тооцоог бодохдоо норм мөрдөөгүй;
- ✓ 11.6 сая төгрөгийн бараа материалын тайланг стандарт шаардлагын дагуу бэлтгээгүй;
- ✓ 2.3 сая төгрөгийн зардлын и баримтыг бүрэн бүрдүүлээгүй;
- ✓ 1.2 сая төгрөгийн зардлын бэлэн мөнгөн гүйлгээний тайланг бэлтгэн гаргаагүй;

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичгийг бэтгэн нийлүүлэгчээс тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;
- ✓ Зам тээврийн сайдын 2019 оны 390-р тушаалын 2-р хавсралтыг мөрдөн ажиллах, автомашины үйлдвэрлэсэн огнооноос шалтгаалан тухайн автомашинд тохирох нормыг зааврын дагуу тогтоон мөрдөх;
- ✓ Эд хариуцагч болон жолоочийн тооцоог хянах ажлыг сайжруулах, эд хариуцагч, жолоочтой тооцоо бодож хэвших;
- ✓ Бараа материалын тайланд материалын орлогыг тусгахдаа материалыг нэр, төрөл, тоо хэмжээгээр нь задалж бүртгэх;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах;
- ✓ Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, бэлэн мөнгөн гүйлгээний тайланг гаргаж хэвших;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Эрдэнэхайрхан сумын Эрүүл мэндийн төв	10	516.9	4	478.5	1	0.3	1	20.4	4	17.7
	Нийт	10	516.9	4	478.5	1	0.3	1	20.4	4	17.7